

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Боловсрол соёл урлагийн газрын  
2017 оны 12 дугаар сарын 31-нээр  
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

**Аудитын код:** БӨА-2018/86/СТА-ТШЗ

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Боловсрол, соёл, урлагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-нөөс 2 дугаар сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Боловсрол, соёл, урлагийн газрын 2017 санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-нөөс 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 23-нд Боловсрол соёл урлагийн газрын удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Боловсрол, соёл, урлагийн газрын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Байгууллагын зорилго нь: Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах

Чиг үүрэг нь: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн хувьд боловсролын асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд шатны бусад байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах чиг үүрэгтэй ажиллана.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Байгууллагын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Боловсрол соёл урлагийн газрын дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Байгууллагын 2017 оны төсвийг БСШУСайдын төсвийн багцаас санхүүжүүлэн аймгийн Төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Боловсрол соёл урлагийн газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 16-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанд БСШУЯамны баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан

төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй болон УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төв ХХК-ны “Аколоус” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Эрүүл мэндийн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн БСШУСайдын төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Боловсрол, соёл, урлагийн газрын төсвийн захирагч нь 2017 онд 335,2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 335,2 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа зарцуулж, 1,2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн бүтцийг авч үзвэл нийт төсвийн 65,6 хувийг цалингийн зардал, 7,4 хувийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 15,7 хувийг бусад бараа үйлчилгээний зардал, 11,1 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

2017 оны батлагдсан орон тоо 25 ба гүйцэтгэлээр 25 байна.

### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллагын шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.2, 6.1.5, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн 316.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнийг албан шаардлага өгч биелэлтийг хангуулж 2017.12.07 №386 тоот албан бичгээр хариуг авсан байна.

**Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

**Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Боловсрол соёл урлагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого-санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, НДШ-ийн зардал, халаалт, ХҮДадлагын зардал, ТГНУОлгох тэтгэмжийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын нийт орлогыг 100 хувь, нийт зардлын 93,9 хувийг хамруулж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг дараах алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

1. Өмнөх оны хувь хүний орлогын албан татварын тооцоогоор гарсан 1477.8 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй орхигдуулсаныг тайланд оны төсвөөс төлсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар, журам, стандартын дагуу үнэн зөв хөтөлж, тооцоог хугацаанд хийж, өр авлагыг баталгажуулж байх талаар албан шаардлага өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг бус дараах алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

1. Газрын зарим ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй байх ажлын онцгой шаардлага гарсаныг нотлох хурлын тэмдэглэл, холбогдох дээд газрын шийдвэр зэрэг нотлох баримтгүйгээр мөнгөн урамшуулал олгосон. Дарга Х.Зауред 2201,3 мянган төгрөгийн, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Р.Серикболд 1315,2 мянган төгрөгийн, нягтлан бодогч Н.Мухтард 317,5 мянган төгрөгийн, нярав Е.Маратад 148,4 мянган төгрөгийн нийтдээ 3982.4 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү тооцож олгосон 1060,0 мянган төгрөгийн урамшууллагын төлүүлэхээр акт тогтоож, ажилтнуудын ээлжийн амралтыг цаашид Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасны дагуу заавал биеэр эдлүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй болно.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай асуудал үгүй байна.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Боловсрол соёлын газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 5,4 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрч 4,2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 1,1 сая төгрөгийг төсөвт төлүүлэхээр акт тогтоов.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад 3 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг он дамжин 2017 оны 10 дугаар сарын 31-ний 321 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг дахин хянаж үзэхэд санхүүгийн програм нэвтрүүлэх, бараа материалын тайлан гаргах талаар өгсөн зөвлөмжүүд бүрэн хэрэгжсэн байна.

Санхүүгийн тайланд өр төлбөрөө тусгаагүй зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй ба тайланд онд энэ зөрчил давтан гарсан байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг түвшингээс доогуур, санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл бага бөгөөд Боловсрол соёл урлагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, албан шаардлага .... хуудас хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:2018.02.22

Х.ЖЕНИСБЕК

Огноо:2018.02.22

Д.НАЗГҮЛ

Огноо:2018.02.22